

ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛЬД МАГИСТРАНТ, ДОКТОРАНТ ШИЛЖҮҮЛЭН СУРАЛЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гадаад, дотоодын ДБСБ-аас ОТИС-д, мөн ОТИС-ийн ахисан түвшний хөтөлбөр хооронд магистрант, докторант шилжин суралцах асуудлыг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Энэхүү журам нь Монгол Улсын үндсэн хууль, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон эдгээрт нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээнд нийцсэн байна.

Хоёр. Шилжилт хөдөлгөөнийг зохицуулах

2.1. Шилжилтийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулах, удирдлагаар хангах ажлыг ОТИС-ийн сургалтын нэгдсэн алба хариуцна.

2.2. Сургалтын нэгдсэн алба нь шилжилтийн ажлыг удирдамжаар хангаж, зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэн, хяналт тавьж оролцох ба тусгай мэргэжлийн хөтөлбөрөөр шилжилт, багц цаг дүйцүүлэх асуудлыг хариуцах комисс байгуулна.

Гурав. Шилжин суралцахад тавих шаардлага

3.1. ОТИС-д шилжин суралцах хүсэлт гаргасан магистр, докторын хөтөлбөрөөр шилжин суралцахаар хүсэлт гаргасан бүртгүүлэгч нь гадаадын их дээд сургуулиас шилжин ирж байгаа бол сүүлийн 2 жилийн дотор нэгээс доошгүй улирал 6-аас багагүй багц цагийн хичээл амжилттай судалж, суралцсан хугацааны голч дүн 2,8-аас доошгүй байна.

3.2. ОТИС-д шилжин суралцах хүсэлт гаргасан магистр, докторын хөтөлбөрөөр шилжин суралцахаар хүсэлт гаргасан бүртгүүлэгч нь дотоодын их сургуулиас шилжин ирж байгаа бол сүүлийн 2 жилийн дотор нэгээс доошгүй улирал 6-аас багагүй багц цагийн хичээл амжилттай судалсан байх, суралцсан хугацааны голч дүн 3,0-аас доошгүй байх ба шилжин ирж байгаа их сургууль нь магадлан итгэмжлэгдсэн байна.

3.3. ОТИС-ийн магистр, докторын хөтөлбөрөөр суралцагч өөр мэргэжлийн хөтөлбөрөөр шилжин суралцах бол хүсэлт гаргах улирлын өмнөх 2 жилийн хугацаанд нэгээс доошгүй улирал 4-аас багагүй багц цаг цуглуулж нийт суралцсан хугацааны голч дүн 2,8-аас дээш бол хүсэлт гаргах эрхтэй.

3.4. ОТИС-ийн магистр, докторын хөтөлбөрөөр суралцагч суралцаж байгаа хөтөлбөртөө хөнгөлөлттэй нөхцөлөөр, эсхүл аль нэг байгууллагын гэрээний дагуу элссэн бол өөр мэргэжлээр шилжүүлэн сургахгүй.

3.5. ОТИС-ийн магистр, докторын хөтөлбөрөөр суралцагч сургалтын хэлбэрээ /Үндсэн болон цагийн/ өөрчлөх бол хүсэлтээ 1 улирлын өмнө сургалтын нэгдсэн албанд гарган шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Шилжилтийн бүртгэл

4.1. Шилжилтийн бүртгэлийг хичээлийн жилд хоёр удаа тухайн улирлын хичээл эхлэхээс 7 хоногийн өмнө дуусгасан байна.

4.2. Шилжин суралцахаар бүртгүүлэгч нь сургалтын нэгдсэн албанд биеэр ирж бүртгүүлэх бөгөөд дараах бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

4.2.1. хувийн өргөдөл

4.2.2. иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиг

4.2.3. суралцаж байгаа сургуулийн суралцагч мөн болохыг баталсан тодорхойлолт /ОТИС-ийн хөтөлбөр хооронд шилжигчид хамаарахгүй/

- 4.2.4. элсэн орсон тухай тушаал /ОТИС-ийн хөтөлбөр хооронд шилжигчид хамаарахгүй/
4.2.5. баталгаажсан дүнгийн тодорхойлолт
4.2.6. магистрын хөтөлбөрөөр суралцагч бол бакалаврын зэргийн, докторын хөтөлбөрөөр суралцагч бол магистрын зэргийн боловсрол эзэмшсэнийг батлах баримт бичиг
4.2.7. цээж зураг 4%
4.3. Тус журмын 4.3-т заасан баримт бичиг гадаад хэл дээр бол албан ёсны орчуулга хийлгэн, нотариатаар батлуулсан байна.
4.4. Дотоодын их сургуулиас шилжин ирж суралцагч бол суралцагчийн мэдээлэл нь боловсролын салбарын нэгдсэн системд бүртгэлтэй байх
4.5. Шилжин суралцах хүсэлт гаргагч нь тогтоосон бүртгэлийн хураамжийг төлнө.

Тав. Шилжилтийн шалгалт

- 5.1. Бүртгүүлэгч нь шилжихийг хүссэн хөтөлбөрийн шаардлагын дагуу шалгалт өгнө.
5.2. Шалгалтын зохион байгуулалтыг сургалтын нэгдсэн алба хариуцан гүйцэтгэнэ. Шалгалтыг мэргэжлийн тэнхим үнэлж үнэлгээг сургалтын нэгдсэн албанд өгнө.
5.3. Шалгалт авах, өдөр, цаг, байр болон шалгалттай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг сургалтын нэгдсэн албаас бүртгүүлэгчид мэдээлэх ба сургуулийн цахим хуудсанд байршуулна.
5.4. Шалгалтад авбал зохих нийт онооны 60-аас доошгүй хувийг авсан бүртгүүлэгчийн өмнөх суралцсан хугацааны голч дүнг харгалзан хяналтын тоонд багтаан элсүүлнэ.
5.5. Хяналтын тоонд багтсан шилжигч сургалтын гэрээ байгуулж, тухайн улирлын сургалтын төлбөрийг төлсөн тохиолдолд удирдлагын мэдээллийн систем ашиглах эрхтэй болно.
5.6. Хяналтын тоонд багтсан шилжигч энэ журмын 5.5-т заасны дагуу бүртгүүлээгүй бол суралцах эрхээсээ татгалзсан гэж үзнэ.

Зургаа. Багц цаг дүйцүүлэх

- 6.1. Шилжин суралцагч өмнө үзсэн мэргэжлийн хичээлийн багц цаг дүйцүүлэхийг тухайн мэргэжлийн хөтөлбөрийн хороонд түшиглэн байгуулагдсан комисс хийж сургалтын нэгдсэн алба баталгаажуулна. Комиссыг сургалтын нэгдсэн албаны дарга томилно.
6.2. Магистрын хөтөлбөрөөр суралцагчийн өмнө судалсан хичээлийн багц цагаас гадаадын ДБСБ бол 9-өөс, дотоодын магадлан итгэмжлэгдсэн ДБСБ-аас бол 6-аас, ОТИС-ийн хөтөлбөр хооронд 10-аас хэтрэхгүй багц цаг дүйцүүлэн тооцож болно.
6.3. Докторын түвшний суралцагчийн өмнө нь судалсан хичээлүүдийн багц цагаас гадаадын ДБСБ бол 12-оос, дотоодын магадлан итгэмжлэгдсэн ДБСБ бол 10-аас, ОТИС-ийн хөтөлбөр хооронд 10-аас хэтрэхгүй багц цаг дүйцүүлэн тооцож болно.
6.4. Шилжин суралцагчийн үзэж судалсан тухайн багц цаг нь ОТИС-ийн харгалзах багц цагт хүрэхгүй бол шилжүүлэн тооцохгүй. Багц цагийн дутууг харгалзах цагийн хэмжээгээр нэмж судлан нөхөн гүйцээх боломжтой байна. Нэмж судлах багц цагийн тооцоог сургалтын нэгдсэн алба гаргаж тухай хөтөлбөрийн багц цагийн үнэлгээгээр тооцон шилжин ирэгч төлснөөр багц цагийг нөхөн гүйцээх боломжтой болно.
6.5. Багц цаг гүйцээх хуваарийг мэргэжлийн тэнхимийн саналд үндэслэн сургалтын нэгдсэн алба гаргана.
6.6. Шилжин суралцагчийн үзэж судалсан тухайн багц цаг нь ОТИС-ийн харгалзах багц цагаас илүү байгаа тохиолдолд ОТИС-д баримталж байгаа тухайн хичээлийн багц цагаар тооцож шилжүүлнэ.
6.7. Хэрэв тухайн сургуулийн багц цагийн тодорхойлолт ОТИС-аас өөр бол мэргэжлийн тэнхимээс зохион байгуулах шалгалтын дүн, судалсан хичээлийн агуулгыг харгалзан сургалтын нэгдсэн алба шилжүүлэн тооцно.
6.8. Судалсан багц цаг, голч дүнг тодорхойлох боломжгүй тохиолдолд уг сургуулийн үнэлгээний тогтолцоо өөр бол хэрхэн харгалзуулах тухай албан ёсны тайлбар эсхүл цахим хуудасны бичвэр шаардах бөгөөд хэрэв боломжгүй бол амжилттай дүнг 60-95 онооны завсарт жигд харгалзуулах замаар шилжүүлэн тооцож болно.
6.9. Дүйцүүлсэн хичээлийг удирдлагын мэдээллийн системд тухайн хичээлийн жилийн шилжиж ирсэн улиралд нэг л удаа оноож оруулна. ОТИС хөтөлбөр хооронд шилжиж байгаа бол үндсэн үнэлгээгээр, бусад гадаад, дотоодын ДБСБ-аас шилжин ирж байгаа бол CR /Credit Ranted/ үнэлгээгээр оруулна.

6.10. Магистр, докторын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тооцохдоо “Магистрант, докторантын эрдэм шинжилгээ, судалгааны багц цаг тооцох” журмыг баримтална.

6.11. Бусад дээд боловсролын сургалтын байгууллагаас шилжин ирж суралцан докторын зэргээ хамгаалах докторант нь диссертаци хамгаалах тухайн улирлын багц цагийн үнэлгээгээр тооцон докторын диссертацийн 24 багц цагийн төлбөрийг төлнө.

Долоо. Бусад

7.1. Бүртгүүлэхээс өмнө шилжих хүсэлт гаргагч нь энэхүү журамтай танилцах үүрэгтэй.

7.2. Шилжилттэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдвол ОТИС-д шилжүүлэн суралцуулахгүй, шилжсэний дараа энэ зөрчил илэрвэл сургуулиас хасах тушаал гарган төлсөн төлбөр тооцоог буцаан олгохгүй.

7.3. Суралцагч зөвхөн нэг удаа шилжин сурахыг зөвшөөрнө.

---o0o---